



## ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/140

Улаанбаатар хот

### Хариуцлагатай жижүүр томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр Наадмын өдрүүд буюу 2020 оны 07 дугаар сарын 11, 12, 13, 14, 15 -ны өдрүүдэд байгууллагын байрны аюулгүй, байдалд хяналт тавих зорилгоор дараах албан хаагчдыг хариуцлагатай жижүүрээр томилсугай:


- 2020 оны 07 дугаар сарын 11-ний өдөр З.Гэрэлмаа
- 2020 оны 07 дугаар сарын 12-ны өдөр С.Урангэрэл
- 2020 оны 07 дугаар сарын 13-ны өдөр Э.Оюунцэцэг
- 2020 оны 07 дугаар сарын 14-ний өдөр О.Амарбат
- 2020 оны 07 дугаар сарын 15-ны өдөр Ч.Эрдэнэбаяр

2. Хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаанд 2-оос доошгүй удаа эргүүл шалгалт хийж тухай бүрт нь тэмдэглэл хийн газрын даргад илтгэж жижүүрийн хугацаанд ажлын байрны цахилгаан, гал, усны болон бусад гэмтэл, зөрчил бусад хүчин зүйл тохиолдсон үед нэн даруй тус газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга /С.Ганзориг/-т болон бусад холбогдох байгууллагад мэдэгдэхийг хариуцлагатай жижүүрт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга /С.Ганзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР



000621